



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 876

Улаанбаатар хот


Г

Г

Журам батлах тухай

Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрмийн 3.1.2, 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагаанд бүтээмжийн арга хэрэгслүүдийг нэвтрүүлж, тасралтгүй сайжруулалт хийх зорилгоор “Ажилтнуудын кайzen санал санаачилгыг хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг нэгдүгээр, 2024 онд кайzen саналыг хэрэгжүүлэх зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Батлагдсан зардлын төсвийг холбогдох эх үүсвэрээс гаргахыг Санхүүгийн хэлтэс /Н.Халиунаа/-т зөвшөөрсүгэй.
- Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /3.Эрдэнэчuluун/-т даалгасугай.



Харилцаа холбооны зохицуулах хорооны
даргын 2024 оны 03 сарын 21. өдрийн
Ажилтнуудын тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Ажилтнуудын кайzen санал санаачилгыг
хүлээн авах, шийдвэрлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмаар байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, ажлын бүтээмж, чанарыг дээшлүүлэх талаар ажилтнуудын гаргасан санал санаачилга, бүтээлч үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх, хөгжүүлэх, урамшуулах, хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Нэр томьёоны тайлбар

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

“Кайzen” гэж:

- ажилтнуудыг шинэ санаа, санал гаргахыг өдөөх, идэвхжүүлэх
- ирсэн саналуудад бодит үнэлгээ өгөх
- тухайн саналыг хэрэгжүүлэх төслийг дэмжих, хэрэгжүүлэх
- саналын хэрэгжилтийг хянаж ажиллах үүрэг бүхий багийг ойлгоно.

“Кайzen санал” гэж:

- санал гаргагч ажилтан хүсэл эрмэлзэлдээ тулгуурлан
- байгууллагын ашиг орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал
- ажлын бүтээмж, чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн санал
- тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах, осол гэмтэл гарахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн санал
- эрчим хүч ба бусад нөөцүүдийг хэмнэхэд чиглэсэн санал
- газар, нэгжийн хоорондын уялдаа холбоог сайжруулах, ажлын давхардлыг багасгахад чиглэсэн санал
- ажилтны болон хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн санал
- байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн санал
- ажилтнуудад зөв хандлага, ажлын зөв соёл, ажлын цаг ашиглалтыг дээшлүүлэхэд чиглэсэн зэрэг шууд болон богино хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх боломжтой санал
- ажил гүйцэтгэх хугацааг багасгах санал
- ажлын гарц, чанарыг сайжруулах, алдаа доголдлыг бууруулах саналыг ойлгоно.

“Санал гаргагч” гэж тогтсон сувгуудаар дамжуулан дангаар болон багаар санал санаачилгаа ирүүлж байгаа ажилтныг хэлнэ.

“Бүтээмжийн баг” гэж ажилтнуудын гаргасан кайzen саналын үр өгөөжтэй эсэхийг тодорхойлох, кайzen саналыг үнэлэх, дэмжигдсэн саналыг хуваарилах, хэрэгжсэн кайzen саналыг үнэлэх, урамшуулахтай холбогдох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий байгууллагын ажилтнуудаас бүрдэх баг.

“Санал хэрэгжүүлэх баг” гэж дэмжигдсэн саналыг хэрэгжүүлэхээр сайн дураар болон томилогдон ажиллаж байгаа 2-5 хүний бүрэлдэхүүнтэй чанарын дугуйланг хэлнэ.

Гурав. Бүтээмжийн багийн бүрэлдэхүүн

3.1. Бүтээмжийн баг дараах бүрэлдэхүүнтэй байна.

3.1.1 Бүтээмжийн багийн ахлагч: Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга

3.1.2 Бүтээмжийн багийн зохицуулагч: Хүний нөөцийн мэргэжилтэн

3.1.3.Бүтээмжийн багийн гишүүд:

- Хуулийн хэлтсийн дарга

- Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн

- Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын суурин хяналтын ахлах инженер

- Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газрын Судалгаа шинжилгээний хэлтсийн дарга

- Зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн

Дөрөв. Бүтээмжийн багийн ахлагчийн эрх, үүрэг

4.1 Бүтээмжийн багийн гишүүдийг багийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай, тогтмол оролцуулах, нэгдмэл удирдлагаар хангах

4.2 Шалгаруулсан саналыг үнэлэх, хэрэгжүүлэх төсвийг тухайн жилийн төсөвт тусгаж, батлуулах, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Тав. Бүтээмжийн багийн зохицуулагчийн эрх, үүрэг

5.1. Бүтээмжийн багийн хурлын товийг зарлах ба гишүүдийн оролцоог хангуулах

5.2 Ажилтнуудын гаргасан “Кайзен” саналыг хүлээн авч, нэгтгэн Бүтээмжийн багт танилцуулж, шийдвэрлүүлэх

Ажилтны гаргасан “Кайзен” саналыг дэмжигдсэн, дэмжигдээгүй эсэхийг ажилтанд албаны цахим хаягаар мэдээлэх.

5.3 Кайзен санал ирүүлсэн ажилтнуудын мэдээллийг Санхүүгийн хэлтэст хүргүүлэн, урамшууллыг олгох,

5.4 Бүтээмжийн багийн шийдвэрийн дагуу хэрэгжсэн саналууд, шилдэг саналын тайлан мэдээллийг байгууллагын дотоод мэдээллийн сувгуудаар ажилтнуудад хүргэнэ,

5.5 Саналыг үнэлэх явцад бүтээмжийн багийн гишүүд үнэлгээ хийгээгүй, үнэлгээ дутуу хийсэн тохиолдолд гишүүдэд шаардлага тавих,

5.6 Багийн ахлагч болон гишүүдийг үнэн зөв мэдээллээр хангах.

Зургаа. Бүтээмжийн багийн гишүүдийн эрх, үүрэг

6.1 Бүтээмжийн багийн гишүүд кайзен саналыг үнэлэх явцад тухайн саналыг нарийвчлан судлах, дэлгэрэнгүй тайлбар авах шаардлага гарвал холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх, удирдлагаас дэмжлэг авах

6.2 Хуралд оролцохдоо тодорхой санал бэлтгэсэн байх

6.3 Багийн гишүүд өөрсдөө санал ирүүлсэн тохиолдолд өөрийн саналын үнэлгээнд оролцохгүй.

Долоо. Кайзен саналыг бүртгэх, хүлээн авах,
саналыг хүлээн авахаас татгалзах

7.1 “Кайзен” саналыг энэхүү журмын хавсралтад заасан маягтын дагуу Бүтээмжийн багийн зохицуулагч /Хүний нөөцийн мэргэжилтэн/-ийн албаны цахим хаягаар болон саналын хайрцаар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүлээн авч, бүртгэл хөтөлнө.

7.2 Кайзен саналыг ажилтан дангаараа болон багаар хамтарч ирүүлж болох ба хамтарч ирүүлсэн саналыг 1 саналд тооцно.

7.3 Ижил агуулга бүхий санал дараалан ирсэн тохиолдолд ирүүлсэн хугацааг харгалзан эхний саналыг үнэлнэ.

7.4 Кайзен саналыг энэхүү журмын 2.1-т тодорхойлсон саналын агуулгаар хүлээн авна.

7.5 Кайзен санал нь хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг тодорхойлсон, ойлгоход хялбар байдлаар бичигдсэн байх ба шаардлагатай нэмэлт баримт тайлбар, зураг, жишээг хавсаргаж болно.

7.6 Ажилтнууд өөрсдийн гаргасан кайzen саналаа энэхүү журмын 6.1-д заасан хугацаанд гаргахаас гадна тодорхой хугацаа, зорилго сэдвийн дор зарлагдах “Кайzen санал”-ын аянд ирүүлж болно.

7.7 Саналын аян зарлагдах бүр шалгуур үзүүлэлтийг тухай бүрт нь зарлана.

7.8 Дараах саналыг хүлээн авахаас татгалзана:

7.8.1. байгууллагын эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааны зарчимтай зөрчилдсөн санал

7.8.2. байгууллагын дотоод дүрэм журам, заавартай илт зөрчилдсөн

7.8.3 хувийн чанартай гомдол, хүсэлт, шүүмжлэл санал

7.8.4 хийсвэр санаа, баримт нотолгоогүй, биелэх боломжгүй санал

7.8.5 гарах бодит үр дүнгээсээ хэтэрсэн төсөв, зардал шаардлагдах санал

7.8.6 хавсралт маягтын дагуу мэдээллийг бүрэн гүйцэд ирүүлээгүй санал

7.8.7 байгууллагын бизнес төлөвлөгөө, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний санал.

7.9 Кайzen санал дэмжигдсэн, дэмжигдээгүй тухай шийдвэрийн хариуг санал гаргасан ажилтанд заавал мэдэгдэнэ.

7.10 Кайzen саналыг үнэлэхэд “Бүтээмжийн баг”-т нэмэлт мэдээлэл шаардлагатай тохиолдолд санал гаргагч ажилтан болон хөндлөнгийн мэргэжилтнээс мэдээлэл авч болно.

Найм. Саналыг үнэлэх

8.1 Кайzen саналыг дараах шалгуур үзүүлэлтээр нийт 20 хүртэл оноогоор үнэлнэ.

д/д	Үнэлгээний шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээний түвшин /1-5 оноо/
1	Саналыг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага	Саналын агуулгад дурдагдсан одоогийн нөхцөл байдал ямар түвшинд байгаа, тэрхүү нөхцөл байдлыг сайжруулах шаардлага өнөөдөр болон ирээдүйд хэр зэрэг хүчтэй тавигдаж байгааг харгалzan үзнэ.	
2.	Саналыг хэрэгжүүлэх нөхцөл боломж	Саналыг хэрэгжүүлэх дотоод нөөц бололцоо буюу хүний нөөц, санхүүгийн нөөц боломж, техник, технологийн шийдлийн одоогийн болон ирээдүйн нөхцөл боломжууд ямар байгаа, мөн гадаад хүчин зүйлс хэрхэн нөлөөлж болохыг харгалzan үнэлнэ.	
3.	Саналыг хэрэгжүүлснээр хүлээгдэж буй үр дүн	Саналыг хэрэгжүүлснээр байгууллагын нэр хүнд, ашиг орлого, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, аль нэг газар, нэгжийн дотоод үйл ажиллагаа болон хэлтэс дамнасан дотоод үйл явцыг сайжруулах, ажилтнуудын ажлын бүтээмж, чанарыг сайжруулах, хүсэн хүлээгдэж буй үр дүнг харгалzan үнэлнэ.	
4.	Саналын өвөрмөц, онцгой байдал	Саналын агуулгад дурдагдсан сайжруулах арга зам, аргачлалын шинэлэг, өвөрмөц, онцлог шийдлийг үнэлнэ.	

Ес.Кайzen саналыг хэрэгжүүлэх, Санал хэрэгжүүлэх баг байгуулах

9.1 Кайzen саналыг “Санал хэрэгжүүлэх баг”-аар дамжуулан хэрэгжүүлж болно.

9.2 Санал хэрэгжүүлэх багийг бүртгэж, үйл ажиллагааг эхлүүлэхдээ дараах горимыг баримтална.Үнд.

9.2.1 Бүтээмжийн багт албан ёсоор бүртгүүлэх

9.2.2 Санал хэрэгжүүлэх багийн гишүүд үйл ажиллагааны онцлогт тохирсон нэр, уриатай байж болно.

9.2.3 Бүтээмжийн баг санал хэрэгжүүлэх баг байгуулагдсан талаар нийт ажилтнуудад дотоод мэдээллийн сувгаар мэдээлнэ.

9.2.4 Бүтээмжийн баг санал хэрэгжүүлэх багийн нийт ажилтнуудад мэдээлснээс хойш ажлын 2 хоногт багтаан хэрхэн ажиллах зөвлөмж зааврыг танилцуулна.

9.2.5 Тухайлсан кайzen саналыг шийдвэрлэх зорилго, төлөвлөгөөтэй байх

9.2.6 Санал хэрэгжүүлэх баг сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдах

9.2.7 Санал хэрэгжүүлэг багийн ахлагчаа өөрсдөө сонгох

9.2.8 Санал хэрэгжүүлэх хугацааг өөрсдөө тогтоох

Арав. Кайzen саналыг урамшуулах

10.1 Кайzen саналыг дараах байдлаар урамшуулна.

№	Үзүүлэлт	Урамшуулал
1	Хүчинтэй санал бүрийг	5.000 төгрөг
2	Хэрэгжсэн санал бүрийг	10.0 төгрөг

10.2. Шилдэг кайzen саналыг урамшуулах

10.2.1 Бүтээмжийн баг нь тухай жилд хэрэгжсэн кайzen саналуудыг нэгтгэн шилдэг кайzen саналыг тухайн жилийн 4 дүгээр улиралд багтаан шалгаруулна.

10.2.2 Шилдэг кайzen саналыг дараах шалгуур үзүүлэлтээр нийт 20 хүртэл оноогоор үнэлнэ.

д/д	Үнэлгээний шалгуур	Үзүүлэлт	Үнэлгээний түвшин /1-10 оноо/
1	Саналыг хэрэгжүүлснээр хүлээгдэж буй үр дүнд хүрсэн эсэх	Саналыг хэрэгжүүлснээр байгууллагын нэр хүнд, ашиг орлого, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, аль нэг газар, нэгжийн дотоод үйл ажиллагаа болон хэлтэс дамнасан дотоод үйл явцыг сайжруулах, ажилтнуудын ажлын бүтээмж, чанарыг сайжруулах, хүсэн хүлээгдэж буй үр дүнг харгалзан үнэлнэ.	
2.	Саналын бүтээлч байдал, үр нөлөө	Санал нь бусад байгууллага болон практикт давтагдаагүй онцгой бүтээлч санаа эсэх байгууллагын томоохон асуудал, бэрхшээлийг шийдвэрлэсэн байдал, байгууллагын соёлд зерэгээр нөлөөлсөн байдал	

10.2.3.Шилдэг кайzen санал нь үнэлгээний түвшингээр 17-20 оноо авсан байна.

10.2.4 Шилдэг кайzen саналаар шалгарсан тохиолдолд ажилтан ганцаараа бие даан хэрэгжүүлсэн тохиолдолд 300 000 /гурван зуун мянга/ төгрөг, багаар хэрэгжүүлсэн тохиолдолд 500 000 /таван зуун мянга/ төгрөгийн урамшуулал олгоно. Тухайн онд 1 шилдэг Кайzen саналыг шалгаруулна.

10.3.Байгууллагын үйл ажиллагаатай уялдуулан кайzen саналын сэдэвт аян зарлаж болох бөгөөд удирдамжийн дагуу зохион байгуулж, урамшууллыг тухай бүр шийдвэрлэж олгоно.

10.4.Хэрэв Бүтээмжийн багийн гишүүд энэхүү журмын 7.1, 8.2.2-т заасан үнэлгээг хийхэд санал тэнцвэл Бүтээмжийн багийн ахлагч эцсийн шийдвэрийг гаргана.

10.5. Шилдэг “Кайзен санал” санал гаргагчийг шалгаруулах, хэрэгжүүлж дууссан санал бүрийг сайшаах, хамгийн олон санал гаргасан ажилтныг алдаршуулах зэрэг ажлуудыг кайзан багийн гишүүд тухай бүр хийж улмаар ажилтнуудын кайзен санал гаргах сэтгэлгээг идэвхжүүлэх ажлыг зохион байгуулна.

Арван нэг. Кайзен саналын хэрэгжилт ба тайлاغнах

11.1 Кайзен саналын хэрэгжүүлэлт дууссаны дараа гарсан үр дүн, амжилтын талаар Санал хэрэгжүүлэх багаар тайлан бичүүлж, удирдлагад танилцуулж, нийт албан хаагчдад мэдээлнэ.

11.2 Санал хэрэгжүүлэх баг томилогдсоноос хойш 2 сарын хугацаанд төслийг хэрэгжүүлж эхлээгүй, хэрэгжүүлэх чармайлт гаргаагүй тохиолдолд саналыг өөр багт шилжүүлнэ.

----o0o----

КАЙЗЕН САНАЛЫН ХУУДАС

Ажилтны нэр	Газар, хэлтэс	Илгээсэн огноо
Саналын нэр: (Юуг сайжруулах вэ)		
Саналын төрөл: <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Зардал бууруулах <input type="checkbox"/> Бүтээмж дээшлүүлэх <input type="checkbox"/> Ажлын гарц, чанарыг сайжруулах <input type="checkbox"/> Ажлын арга барил сайжруулах <input type="checkbox"/> Ажлыг стандартжуулах <input type="checkbox"/> Ажил гүйцэтгэх хугацааг багасгах <input type="checkbox"/> Шинэ бүтээгдэхүүн бий болгох <input type="checkbox"/> Хэрэглэгчийн үйлчилгээг сайжруулах <input type="checkbox"/> Бусад 		
Одоогийн нөхцөл байдал/Гарч буй асуудлууд: <i>(Ямар асуудал гарч байгаа вэ, яагаад энэ асуудлыг шийдвэрлэх шаардлагатай вэ?)</i>		
Сайжруулах санал: <i>(Асуудал нөхцөл байдлыг хэрхэн сайжруулах вэ, сайжруулсны дараа ямар өөрчлөлт гарах вэ?)</i>		
Хэрэгжүүлэх арга зам: <i>(Сайжруулалтыг хийхэд ямар ажил хийгдэх вэ?)</i>		
Хүлээгдэж буй үр дүн, үр ашиг: <i>(Сайжруулалт хийснээр ямар үр дүн, нөлөөлөл гарах вэ)</i> <ol style="list-style-type: none"> 1. 2. 3. 4. 5. 		

Харилцаа холбооны зохицуулах хорооны
дэргүн 2024 оны ... сарын ... өдрийн
... тушаалын хоёрдугаар хавсралт

“КАЙЗЕН САНАЛ-2024” ЖУРМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Кайзен хүчинтэй санал	30*5.000	150.000
2	Кайзен хэрэгжсэн санал	5*10.000	50.000
3	Шилдэг кайзен санал /1 ажилтан/	1*300.000	300.000
4	Шилдэг кайзен санал /баг/	1*500.000	500.000
Нийт			1,000,000